

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР
ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО

2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2025 оны 12 дугаар сарын 31

Улаанбаатар хот

1. Ус сувгийн удирдах газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд цаасаар 2, өргөдөл, гомдлын ERP-Ulaanbaatar нэгдсэн системээр 1 өргөдөл, гомдлыг хүлээн авч судлан шийдвэрлэсэн. Судлан шийдвэрлэсэн дээрх 3 өргөдөл гомдлын 1 нь тухайн өргөдөл, гомдолд нэр дурдагдсан 2 ажилтны ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа гаргасан ёс зүйн зөрчил биш, гэр бүлийн холбогдолтой асуудал байсан. Бусад 2 нь ажилтнуудын харилцаа хандлага, удирдах, удирдуулах ёс зүйтэй холбоотой байсан.

Дээрх 3 өргөдөл, гомдлыг дэд хорооны хурлаар хэлэлцүүлж, ёс зүйн зөрчил гаргасан тухай 1 дүгнэлт гарган Захиргаа удирдлагын хэлтэст өгч, өргөдөл, гомдолд нэр дурдагдсан 5 ажилтанд зөвлөмж хүргүүлсэн.

2. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 15 ажил тусгагдсан бөгөөд дундаж биелэлт 85%-тай байна.
3. Байгууллагын Ёс зүйтэй ажилтнаар 2024 онд шалгарсан ажилтнуудтай цаашид хамтран ажиллах чиглэлээр санал солилцох уулзалтыг 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан.
4. Ёс зүйн дэд хорооноос ёс зүй, ажил хэргийн ёс зүйн зорилго, зарчмын талаар богино хэмжээний 4 төрлийн видео танилцуулга, мэдээллийн баннерыг бэлтгэн, ёс зүйн өдөрлөгийн үеэр ажилтнуудад үзүүлж, ёс зүйн талаар болон ажил хэргийн ёс зүйн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэн ажиллаж байна.
5. Ёс зүйн дэд хорооны хурлыг 5 удаа зохион байгуулж, дэд хорооны үйл ажиллагааны талаар хэлэлцсэн.
6. Нөлөөллийн аяныг 6 удаа, ёс зүйн өдөрлөгийг 9 удаа зохион байгуулж, тайлан, мэдээллийг байгууллагын дотоод фейсбүүкт байршуулан ажилласан.
7. Нийт ажилтнуудын ёс зүйн тухай ойлголт мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг Ёс зүйн академитай хамтран зохион байгуулсан бөгөөд нийт 1200 гаруй ажилтан цахимаар хамрагдсан.
8. Ерөнхий сайдын 03 дугаар албан даалгаврын 2 заалтын биелэлтийг сар бүр, Улсын их хурлын ёс зүй, дэгийн байнгын хорооны 2025 оны 04 дүгээр тогтоолын 3 заалтын биелэлтийг 1 удаа гарган байгууллагын тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэнд цахимаар өгсөн.

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО